



Монгол улсад 2023 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ

Монгол Улсын Засгийн газар (“Засгийн газар” гэх) Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын гадаадаас авах ажилтны хувь хэмжээг жил бүр шинэчлэн тогтоодог билээ. Монгол улсад 2023 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг Засгийн Газар 2022 оны 10 дүгээр сарын 5-ны өдрийн 359 тоот тогтоолоор (“Засгийн газрын 359-р тогтоол” гэх) шинэчлэн тогтоолоо.

Холбоо барих:

Майкл Ахэрн

Партнер

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
michael.ahern@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Рэгчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээний Менежер

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Батчулууны Амаржаргал

Ахлах хуульч

Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
amarjargal.batchuluun@pwc.com

Өмгөөллийн

ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар

603 тоот, Улаанбаатар

14200, Монгол улс

Утас : + 976 70009089

Факс : +976 11 322068

www.pwc.com/mn



Засгийн газрын 359-р тогтоолд зааснаар эдийн засгийн үйл ажиллагааны салбараар тогтоосон Монгол улсад 2023 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо нь 2023 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ. Монгол улсад 2023 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоог эдийн засгийн үйл ажиллагааны салбараас хамааран мэдээлэл, холбооны салбарт 2, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт 3, барилгын салбарт 3644 ба уул уурхай олборлох салбарт 8000 зэргээр 2-8000 хүртэлх ялгаатай тоогоор нийт 20351 тооны гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгохоор тогтоосон байна.



Юу өөрчлөгдсөн бэ ?

2022 оны 7 дугаар сарын 1- ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль (“АХШХТХ”) -ийн 22 дугаар зүйлийн 22.1-д зааснаар Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор Засгийн газар тогтоохоор заасан. Үүний дагуу Засгийн газрын 359-р тогтоолд Монгол ажилтны тооноос шалтгаалалгүйгээр **гагцхүү эдийн засгийн үйл ажиллагааны салбараас хамааран** 2023 онд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо хэмжээг тогтоосноороо өмнө оны буюу 2022 оны гадаадаас авах ажилтны хувь хэмжээг тогтоосон тогтоолоос ялгаатай байна.

Түүнчлэн, тус 2022 оны гадаад ажилтны тоо, хувь хэмжээнд Мэдээлэл, холбоо (2), Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа (41), Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа (3), Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал (73), Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн, нэр төрлөөр нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ (300) салбаруудад тухайлан гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тусгаагүй байсан бол Засгийн газрын 359-р тогтоолд тус бүрийг оруулж зохицуулсан байна.



Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-өөс бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцаагүй болно.

© 2022 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-г илэрхийлнэ.



Бид дараах салбаруудад тогтоосон гадаад ажилтны тоо болон нийт гадаад ажилтны тоонд эзлэх хувийг онцолж байна.

Салбар	Тодорхойлолт	Гадаад ажилтны тоо	Нийт гадаад ажилтны тоонд эзлэх хувь
A	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	108	0.53%
B	Уул уурхай, олборлолт	8000	39.31%
C	Боловсруулах үйлдвэрлэл	984	4.84%
D	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1511	7.42%
F	Барилга	3644	17.91%
G	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	2118	10.41%
H	Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	1642	8.07%
K	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	41	0.20%
L	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	3	0.01%
N	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	248	1.22%
P	Боловсрол	980	4.82%
U	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	96	0.47%



Ямар үр дагавартай вэ?



АХШТХ-д зааснаар Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн хүрээнд ажиллах хүчийг дотоодоос хангах боломжгүй нөхцөлд нэмэлтээр гадаад ажилтан авч ажиллуулах шийдвэрийг Засгийн газар гаргана. Харин хувийн хэвшлийн санхүүжилтээр хэрэгжих улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, барилга, байгууламж барихад шаардагдах ажиллах хүчийг дотоодоос хангах бололцоогүй нөхцөлд Засгийн газраас тусгайлан шийдвэр гаргах замаар гадаадаас ажиллах хүчний тоог нэмэгдүүлдэг байдал цаашид үргэлжлэхгүй гэж ойлгож байна.

Цаашлаад, АХШТХ-д зааснаар орон нутгийн болон эрх бүхий хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллага шаардлага тавьсан тохиолдолд ажил олгогч нар тухайн байгууллага дахь гадаадын ажилтны тооны 30 хувиас доошгүй ажлын байранд бүртгэлтэй ажилгүй иргэнийг дагалдуулан сургах болон ажлын байраар хангах үүргийг хүлээх болсон. Энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн ажил олгогчийн гадаад ажилтныг урих эрхийг **2 жилийн** хугацаанд хязгаарлахаар зохицуулсан байна.



Энэхүү мэдээлэлтэй холбоотой нэмж тодруулах зүйл байвал бидэнтэй холбогдоно уу.

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах линкнээс авна уу: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16531616560921>



Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотерхаусКүүпэрс Легал ХХН-ээс бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2022 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотерхаусКүүпэрс Легал ХХН -г илэрхийлнэ.